

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 - 22

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төсөл /Засгийн газраас 2024.08.28-ны өдөр нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

1.

5 - 22

**Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны
2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны
ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 10 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн;

Чөлөөтэй: А.Ундраа;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан;

Тасалсан: Н.Алтанишагай, Х.Баттулга, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, О.Цогтгэрэл.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж хариулж, тайлбар хийв.

Нэг.Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төсөл /Засгийн газраас 2024.08.28-ны өдөр нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, мөн хэлтсийн ахлах шинжээч Б.Пунцагбалжир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн талаар Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Г.Уянгахишиг, М.Энхцэцэг, Д.Энхтүвшин, С.Цэнгүүн нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Ч.Лодойсамбуу, Р.Сэддорж нар үг хэлэв.

Р.Сэддорж: Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 50 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
16 цаг 10 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны гишүүдийн өдрийн мэндийг хүргэе. Гишүүддээ.

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан эхлэхэд бэлэн боллоо.

Та бүхэнд ирц танилцуулъя.

Ж.Алдаржавхлан гишүүн өвчтэй, М.Бадамсүрэн гишүүн гадаадад томилолттой, Р.Батболд гишүүн ирсэн, О.Батнайрамдал гишүүн ирсэн, Н.Батсүмбэрэл гишүүн ирсэн, П.Батчимэг гишүүн ирсэн, Э.Батшугар гишүүн ирсэн, Б.Жаргалан гишүүн ирсэн, Ч.Лодойсамбуу гишүүн ирсэн, Г.Лувсанжамц гишүүн ирсэн, М.Мандхай гишүүн ирсэн, Б.Мөнхсоёл гишүүн ирсэн байна, Л.Соронзонболд гишүүн ирсэн, А.Ундраа гишүүн чөлөө авсан байна, Г.Уянгахишиг гишүүн ирсэн, С.Цэнгүүн гишүүн ирсэн, Д.Энхтүвшин гишүүн ирсэн, М.Энхцэцэг гишүүн ирсэн.

Ирц 60 хувьтай байгаа тул Байнгын хорооны өнөөдрийн хуралдаан эхэлснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны эрхэм гишүүдийн амгаланг дахин эрье.

Ингээд Байнгын хорооны гишүүд 60.0 хувьтай хуралдаж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэндээ танилцуулъя.

Нэг.Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг зөвшилцөх.

Энэ саналыг Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдөр зөвшилцөхөөр хүргүүлсэн.

Тэгээд яаралтай. Санал, дүгнэлтээ Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороонд бид хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Ингээд хэлэлцэх асуудлыг баталсанд тооцъё.

Б.Жаргалан гишүүний микрофоныг өгье.

Б.Жаргалан: Ээлжит бус чуулган сая хаалтаа хийчихсэн шүү дээ. Тийм ээ?

Тэгэхээр дэгийн дагуу Байнгын хороодууд хуралдаж шийдвэр гаргах нь хэр зохимжтой вэ? Болох уу? Тийм ээ. Баярлалаа.

Р.Сэддорж: Байнгын хороод чуулганы чөлөөт цагт хуралдах эрхтэй учраас өнөөдрийн хуралдааныг явуулж байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төсөл /Засгийн газраас 2024.08.28-ны өдөр нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэх асуудал. Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг төслийн хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцээрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн хийнэ.

Сайдын танилцуулга хийхийг урьж байна. Микрофоныг өгье. 3 дугаар микрофон.

Б.Чойжилсүрэн: Эрхэм Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлийн дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станцад суурилагдсан хүчин чадлыг цахилгаанаар 300 мегаваттаар дулаанаар,

395 мегаваттаар үе шаттай өргөтгөн шинэчлэх төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд байгуулах “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг боловсруулан 2024 оны 4 дүгээр сард Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайдад хүргүүлсэн.

Оросын Холбооны Улсын Эрчим хүчний яамнаас уг хэлэлцээрийн төсөлд Оросын Холбооны Улсын Засгийн газрын холбогдох яамдын саналыг авч тусган хариу саналыг 2024 оны 7 дугаар сард ирүүлсэн.

Тус хэлэлцээрийн төсөлтэй холбоотой зарчмын зөрүүтэй асуудлаар хоёр улсын Эрчим хүчний яам хооронд 2024 оны 8 дугаар сард харилцан зөвшилцөж ажиллалаа.

Мөн Оросын эрчим хүчний сайдын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ю.Сорокинаас 2024 оны 8

дугаар сарын 21-ний өдөр ирүүлсэн 13/232/М/Д тоот албан бичигт 2024 оны 9 дүгээр сард зохион байгуулагдах Монгол Улс, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нарын уулзалтын үеэр энэхүү хэлэлцээрийн төсөлд гарын үсэг зурах арга хэмжээг зохион байгуулах саналаа ирүүлсэн.

Хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн тохиолдолд Олон улсын гэрээний тухай хуулийн хүрээнд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой урьдчилан зөвшилцөх бөгөөд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дүгнэлтийг үндэслэн Ерөнхий сайдын захирамжаар хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Эрчим хүчний сайдад олгож, улмаар хэлэлцээрийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж соёрхон батлуулна.

Энэхүү хэлэлцээрийн төсөл нь нийт 11 зүйлтэй бөгөөд тус хэлэлцээрт Дулааны гуравдугаар цахилгаан станцын өндөр даралтын хэсгийг 50 мегаваттын блок станцаар өргөтгөх, дунд даралтын 48 мегаваттын блок станцыг буулгаж, суурин дээр нь 2-ыг үржих 125 мегаваттын блок станц шинээр барих төслийн зураг төсөл боловсруулах инженерийн судалгаа, шинжилгээ явуулах, ажлын цар хүрээ, ерөнхий нөхцөлийг тодорхойлж, захиалагчаар дулааны дээд ДЦС 3 ТӨК, гүйцэтгэгчээр Оросын талаас эрх олгосон “Интер РАО Экспорт” компанийг томилох асуудлыг тус тус зохицуулахаар тусгасан.

Зураг төслийн ажлын хүрээнд Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн барилга угсралтын ажлын нийт төсөвт өртөг, хугацааг нарийвчлан тодорхойлж, цаашид Оросын Холбооны Улсын Засгийн газрын экспортын зээлийн

нөхцөл, барилга угсралтын ажил гүйцэтгэх зэрэг асуудлыг Оросын талтай хэлэлцэн тохиролцох нөхцөлийг бүрдүүлэх үндсэн баримт бичиг болох юм.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон улсын гэрээний тухай хуулийн хүрээнд хэлэлцээрийн төсөл, Засгийн газрын хуралдаан тэмдэглэлийн төсөл болон Ерөнхий сайдын захирамжийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн танилцуулж байна.

Засгийн газрын гишүүдээс нийт 25 санал ирснээс 5 саналыг хүлээн авч, 20 саналыг тайлбарласан болно.

“Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл боловсруулах тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг дэмжин шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Нансалын Тавинбэх, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Батмөнхийн Ерэн-Өлзий, Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга Ганбаатарын Энхтүвшин, Эрчим хүчний яамны ахлах шинжээч Батмөнхийн Пунцагбалжир.

Хэлэлцээрийн төслийн талаар асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү?

Н.Батсүмбэрэл гишүүнээр тасаллаа. С.Цэнгүүн гишүүн орж ирсэн. С.Цэнгүүн гишүүнээр тасалъя.

Ингээд Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Энэ төсөл маш олон жилийн туршид явагдаад тэгээд огт тийм амжилттай хэрэгжихгүй байсан гэдгийг ойлгож байгаа.

Тэгээд яагаад яг гэнэт ингэж оруулж ирэх болов оо гэсэн нэг асуулт байна.

Тэгээд Дулааны гуравдугаар цахилгаан станцыг өргөтгөх нь зайлшгүй хэрэг.

Тэгээд зөвхөн Оросуудтай хэлэлцээр хийсэн үү? Эсвэл өөр бас гуравдагч улс орнуудтай хэлэлцээр хийсэн үү?

Тэгээд энэ танилцуулга дээр байгаа үнийн тал дээр асуудлууд их байна. Тийм ээ.

Нийт 1.3 тэрбум евро гэсэн байна.

Тэгэхээр 1 мегаваттын үнэ 4.4 сая ам.доллар болж байна.

Тэгэхээр энэ бол одоо бас маш өндөр үнэ байна гэж харж байна.

Тэгээд рублийн зээл гэж дурдагдсан боловчиг хөрөнгө оруулалт нь болохоор еврогоор илэрхийлэгдээд байх юм. Тэр нь ямар учиртай юм.

Тэгээд ер нь энэ цаг үед ийм рублийн зээл авах нь зөв үү, буруу юу гэдэг асуудал байна.

Тэгээд энэ хэлэлцээрийн 3 дугаар зүйл дээр Монгол Улсын хууль тогтоомжид заасан худалдан авах ажиллагаа явуулахгүйгээр Монголын талын эрх олгогдсон байгууллага Оросын талын эрх олгогдсон байгууллагатай зураг төслийн гэрээ байгуулна гэхчхэн байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ одоо бас хууль зөрчиж байгаа л заалт гэж харагдаж байна.

Тэгэхээр хэрэв бид өөрсдөө ТЭЗҮ-гийн мөнгөө гаргах юм тэр ТЭЗҮ-гээ болохоор заавал энэ Оросын талын заасан тэр гүйцэтгэгчтэй байгуулахгүй, одоо ТЭЗҮ өөрсдөө тэгээд мөнгөө гаргаад хийж байгаа бол хэн дуртай хүнтэйгээ л байгуулж болох байлгүй дээ. Тийм ээ.

Тэгээд хэлэлцээр дээрээ бас ийм зүйл оруулаад ирчихсэн байж байна.

Тэгээд манай тал захиалагч тал. Жишээлбэл, 5 дугаар зүйл дээр орос хэлийг давуу хэл болгон баталгаажуулна гэх мэтчилэн ерөнхийдөө захиалагч талын хүсэл зориг энэ хэлэлцээрт хэр их илэрхийлэхэд орсон юм бэ?

Тэгээд энэ хэлэлцээр ер нь өнгөрсөн хугацаанд хэдэн удаагийн. Одоо яг анхных нь драфт нь хаана байгаа юм?

Одоо энэ хэлэлцээр байгуулагдлаа гэж бодоход процесс цаашаа яг яаж явахыг бас нэг нарийн тайлбарлаад өгөөч гэж асуух байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Хариулт. 3 дугаар микрофон. Б.Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Б.Жаргалан гишүүний асуултад хариульъя.

Гэнэт яагаад оруулаад ирэв гэж байна.

Би 2022 оны 8 сарын 30-нд үүний түрүүчийн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд Эрчим хүчний сайдаар томилогдсон.

Намайг томилогдсоны дараа 2022 оны 9 дүгээр сарын дундуур миний түрүүчийн сайдаар эхлүүлээд явж байсан төсөл. Техник, эдийн засгийн үндэслэлээ Оросын Холбооны Улсын “Интер РАО” компанид хийлгээд ирүүлчихсэн байгаа юм.

1 тэрбум 326 сая еврогоор цахилгаанаар 300 мегаватт, дулаанаар 400 орчим мегаваттын ийм төслийг хэрэгжүүлнэ гэдэг ийм саналыг ирүүлдэг.

Бид энэ чинь хэт өндөр үнэтэй байна. Ийм үнээр чадахгүй ээ. Санхүүжилтийн нөхцөлийг тохирьё. Үнээ буулга гэдэг ийм шаардлагыг сүүлийн 2 жилийн хугацаанд хэд хэдэн удаа хэлэлцээр хийгээд явсан.

Тэгэхээр Оросууд зөрүүлээд хэлдэг юм байгаа.

Нарийвчилсан зураг төсөвгүй, инженерийн судалгаагүй болохоор бид урьдчилж энэ үнийг эцэслэн тохирох бололцоогүй байна.

Та нар мөнгөө гаргаад танай объект болох юм чинь зургаа хийчихье.

Зургаа хийчихсэн тохиолдолд үнийг тохирчих болох болов уу гэсэн ийм байр суурь илэрхийлээд өнөөдрийг хүртэл явж байгаа юм.

Гэнэт оруулж ирсэн гэдэг нь 9 сарын 03-ны өдөр магадгүй Оросын Холбооны Улсын ерөнхийлөгч Владимир Путин Монгол Улсад айлчлах үед энэ гэрээнд зурья гэдгээ хоёр улсын Засгийн газар илэрхийлээд явж байгаа.

Энэ зөвхөн зураг төсөл боловсруулах нь шүү.

Түүнээс биш ерөнхий барилга угсралтын ажил, төслийг эхлүүлэх тухай биш.

Үүнийг бид одоо ингээд Их Хурлаар Та бүхнээс зөвшилцөх эрхээ аваад гэрээнд зурчхаад, намрын чуулган эхлэхээр соёрхон батлуулахаар оруулж ирнэ.

Ингээд явсан тохиолдолд 2026 оны хоёрдугаар улирал хавьцаа энэ зураг төсвийн ажилтай ер нь ерөнхийдөө үнэ нь ямар хэмжээнд, ямар цар хүрээтэй, ямар ажил гэдэг нь тодорхой болсон тухайн үед гэрээг байгуулах тухай асуудлууд ярина.

Зөвхөн Оросын Холбооны Улстай хийх нь зөв үү гэсэн ийм асуулт тавьж байна.

Одоо яг бодит байдал дээр нүүрсний төслийг санхүүжүүлдэг барууны улс орнуудын ямар ч санхүүгийн байгууллага байхгүйг Та мэдэж байгаа.

Дээр нь нэмээд Хөрөнгийн биржид бүртгэлтэй, “stocklist”-д бүртгэлтэй компаниуд нүүрсний төсөлд

тоног төхөөрөмж нийлүүлэхээ
больчихсон ийм байна.

Дээрээс нь нэмээд манай Хятад
Улс 2021 онд Нэгдсэн Үндэстний
Байгууллагын чуулган дээр Си Зиньпин
дарга Хятадын газар нутгаас гадна
цахилгаан нүүрсийг цахилгаан станцыг
санхүүжүүлэхгүй гэдэг ийм амлалтаа
авчихсан.

Хятадын бүх шатны төрийн
шийдвэр болоод авчихсан учраас энэ
2015 оны Парисын хэлэлцээрээс өмнөх
санхүүжилтийн бололцоо шулуухан
үнэнийг хэлэхэд 90 хувь нь хумигдчихсан
ийм л байгаа юм.

Тэгэхээр Оросын Холбооны
Улсаас бид үүнийг одоо хэрэгжүүлье
гэдэг саналыг 2019 онд тухайн үеийн
Засгийн газрынхан тавьж байсан юм
билээ.

Бид энэ Засгийн залгамж
чанараараа энэ төслийг дэмжээд Оросын
Холбооны Улсаас зээл нь, үнэ нь буучих
юм бол.../минут дуусав/

Р.Сэддорж: Б.Чойжилсүрэн сайд
гүйцээж хэлье.

Б.Чойжилсүрэн:

Санхүүжилтийн нөхцөл, бусад
нөхцөлүүдийг нь эцэслээд тохирно.

Тэр үед дахиад Их Хурлаар
оруулж ирнэ. Их Хурлын хяналтаас
гадуур ямар нэгэн юм байхгүй. Ийм л
юм.

Нэг зүйл. Олон улсын гэрээ
байгуулж байгаа нь, зураг төсөв дээр
байгаа нь манай тендерийн хууль
мөрдөгдөхгүй ээ.

Олон улсын гэрээ байгуулсан
тохиолдолд олон улсын гэрээ нь давуу
хүчинтэй байдгийг Та бүхэн мэдэж
байгаа. Энэ бол ийм зүйл.

Еврогоор илэрхийлж байгаа нь
Оросууд 1 тэрбум 326 сая евро гэж 2022
оны 9 сард ирүүлж байсан.

Бид нарт зориулаад рублиэр
өгчхөөч ээ, хүүгээ буулгачхаач ээ гэдэг
ийм хэлэлцээрийн төслүүд явж байгаа.

Бид рублиэр зээлийг чинь авчихъя
гэдэг. Хүүг нь буулга гээд.

Оросын Холбооны Улсын
Сангийн сайдтай би А.Г.Силуановтой
хоёр, гурван удаа уулзсан.

Хөнгөлөлтийн нөхцөлөө нэмээч
гэдэг ийм юунууд тавьж байгаа.

Орос хэлийг давуу болгох гэж
байгаа. Энэ тийм байгаа.

Энэ Оросын Холбооны Улсын
стандартыг мөрдөнө өө.

Манай улсад цахилгаан эрчим
хүчний стандарт бараг Оросын Холбооны
Улсын стандарт огт зөрөхгүй байгаа.

Гэхдээ Оросын Холбооны Улсын
компани байгаа. Сүүлийн 30 жилийн
туршид ийм хүчин чадалтай том станц
ашиглалтад ороогүй учраас шулуухан
юуг нь нуух вэ.

Манай стандартууд маань бас яг
иж бүрэн энэ төслийг явуулах хэмжээний
иж бүрэн болоогүй байна.

Энэ төслийг явуулангаа
“ажиллангаа суралцангаа” гэдэг шиг бид
шаардлагатай стандартуудаа бид цуг

ажлынх нь зургийг нь бид боловсруулаад явна гэсэн ийм байр суурьтай байгаа.

Р.Сэддорж: Б.Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Сая Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр баталсан.

Тэргүүлэх чиглэлүүд гэдэг дээр ерөнхийдөө эрчим хүчний реформ хийх, эрчим хүчний тусгаар тогтнолтой байх гээд л бид бас маш тийм давилуун зорилтуудыг оруулж өгсөн байгаа.

Тэгмэгц яг тодотголтой нийлүүлээд араас нь тэгээд бас энэ хэлэлцээр орж ирж байна.

Ерөнхийдөө зөвхөн Эрчим хүчний яаман дээр гэхэд саяын тодотгол дээр нэмсэн нөгөө Бөөрөлжүүтийн станцын асуудал байж байгаа. Тийм үү? Тэгээд араас нь гуравдугаар цахилгаан станцын асуудал ороод ирж байна.

Тэгэхээр дандаа нүүрс дээр өөр газраас мөнгө босохгүй байгаад байна ч гэдэг юм уу. Тийм ээ. Нэг тийм тайлбартай.

Бас магадгүй арай өөр зохицуулалтууд хийх боломжтой ийм гэрээнүүд орж ирж байгаа нь жоохон асуудалтай байгаад байна.

Тэгээд цаашид бид хэрэв дотоодын нөөцөөс ч гэдэг юм уу, дотоодын эх сурвалжаасаа ч гэдэг юм уу, дотоодын биржээрээ дамжуулаад ч гэдэг юм уу бас арай тийм мөнгө босгох санхүүгийн илүү инновацлаг аргуудыг хэрэгжүүлэхгүй бол ерөнхийдөө эрчим хүчний тусгаар тогтнол чинь бас бүрэн бүрэлдэхгүй л юм шиг санагдаж байна.

Тэгээд нөгөө талаас одоо жишээлбэл энэ хэлэлцээр дээр ч гэсэн хэрэв манайх ТЭЗҮ-гээ өөрсдөө санхүүжүүлнэ гэж байгаа бол зөвхөн тэр ТЭЗҮ-тэй холбогдолтой зүйлийг нь тусад нь одоо тийм нэг гэрээ болгоод, тэгээд өөрсдөө тэрийгээ зарлаад явж болохгүй байх байсан юм уу?

Заавал одоо ингээд ийм үргэлжилсэн нэг ийм хэлэлцээрийн үе шат руу оруулах нь ямар хэрэг байгаа юм бэ гэдэг ийм асуудал байгаад байгаа юм.

Бид нэгэнтээ ТЭЗҮ дээрээ өөрсдөө мөнгө гаргах юм бол ТЭЗҮ-гээ магадгүй өөр гаднын компаниар хийчхээд дараа нь Оросуудтайгаа хэлэлцээр хийж болно шүү дээ.

Р.Сэддорж: Хариулт. 3 номер.

Б.Чойжилсүрэн: Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Өөрсдөө мөнгөө босгочихдог, өөрсдөө төсвөөсөө хийчихдэг байсан бол юу гэж эд нарыг ингэж гуйж явах вэ. Б.Жаргалан.

Аргагүйд нь ороод ийм болчхоод байна шүү дээ.

Жилдээ 260 мегаваттаар манай эрчим хүчний хэрэглээ өвлийн сарууд дээр нэмэгдээд байгаа юм.

Бид нарыг санхүүжүүлээд өгье, гээд тийм очер дараалал үүсчихсэн бид нарыг гуйж байгаа юм огт алга. Байгаа боломж нь л энэ.

Бид ТЭЦ-II-ыг жишээлбэл яг одоо өөрийн чинь яриад байгаа шиг бид өөрсдөө ТЭЗҮ-гээ боловсруулаад дотоодынхоо эх үүсвэрээр 30 хувийг нь

Монголын тал санхүүжүүлээд, 70 хувь дээр нь төслийн зээл авъя гээд ийм тендер дахиад зарлах гээд явж байна.

Тавантолгойн цахилгаан станц ч мөн ялгаагүй ийм байдлаар зарлагдчихсан. Шүүхийн шийдвэр нь давж заалдах шүүхийн шийдвэр гарсан юм билээ. Ойрын хоёр сарын дотор Тавантолгойн цахилгаан станц ажлаа хийх гараанаас гарчих болов уу гэж бодож байгаа.

Байгаа царай нь энэ. Бидний.

Р.Сэддорж: Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Би санал хэлье.

Нөхцөл байдал өөрөө жоохон амаргүй байгаа гэдгийг Б.Чойжилсүрэн гишүүн хэлж байна.

Тэгэхээр яалт ч үгүй л бас эрчим хүчний эх үүсвэрээ нэмэгдүүлэх зайлшгүй бодитой цаг үетэй бид таарч байна.

Жилээс жилд эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж байна. Эх үүсвэрүүд маш хүндэрч байна гэдэг ийм мэдээллийг бид авч байгаа.

Энэ гуравдугаар цахилгаан станц 1968 онд ашиглалтад ороод ер нь ашиглалтын хувьд нэлээн хүнд байдалтай байгаа юм байна гэдгийг албаны мэдээлэл авсан.

Тэгэхээр энэ ажлыг ер нь богино хугацаанд шуурхай хийх, цаашдаа энэ нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээний хангамжийг шийдэх дээр нь бодитой дэмжээд явчих нь зүйтэй байх гэж би бодож хэлж байна.

Цаашдаа гишүүдийн хэлээд байгаа, бидний яриад байгаа эрчим хүчний эх үүсвэрүүдийг олон хэлбэрээс бүрдүүлэх, үнийг чөлөөлөх, хэрэглээг бодитой болгох гээд л олон асуудлууд дээр Эрчим хүчний яам шуурхай ажиллах зайлшгүй шаардлага байна.

Эдийн засгийн байнгын хороо ч гэсэн энэ эрчим хүчний чиглэлийн төслүүдтэй бодитойгоор яг биечилж очиж танилцах, яг бодит амьдрал дээрээ дулааны станцууд ямар байгаа юм, энэ бодит хэрэглээ маань ямар байна вэ гэдгийг үзэх нь зүйтэй байх гэж би санал Байнгын хорооны даргад хэлэх байна.

Тэгээд энэ асуудлыг дэмжиж байна.

Тэгээд шуурхай богино хугацаанд хийх хэрэгтэй.

Ер нь бид нарын байгаа байдал өнгөрсөн жил эрчим хүчний хязгаарлалтад орчихсон. Өвлийн хүйтний улирал эхэлж байна.

Эрчим бат хүчний байдал цаашаа хүндрээд байвал яах вэ. Үүнийг их л шуурхай шийдэх хэрэгтэй байна даа.

Энэ дээр шуурхай ажиллаасай л гэж захиж хэлэх байна.

Тэгээд дэмжиж байна.

Р.Сэддорж: Санал хэллээ. Тийм ээ.

Гончигдоржийн Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Энэ дээр үндсэн гурван асуулт байна.

Нэгдүгээр асуулт. Энэ танилцуулга дээр байгаа Оросын талаас ирүүлсэн ТЭЗҮ-гийн үнэ өндөр байсан. Монголын талаас ТЭЗҮ хийгээд бас үнийг арай бууруулж санал өгсөн байгаа. Тийм ээ.

Тэгэнгүүт Оросын талаас ТЭЗҮ хийсэн компани маань “Интер РАО Экспорт” гээд компани байгаа шүү дээ.

Тэгэнгүүт зураг төслөө яг энэ компани маань хийх болчихож байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ зураг төслийн ажил хийх гол зорилго маань аль талын ТЭЗҮ илүү бодитой вэ гэдгийг уг нь гаргаж ирэх гээд байгаа буюу хугацаа нь хэдий хугацаанд үргэлжлэх юм, ямар санхүүжилтээр хийгдэх юм гэдэг юмыг энэ зураг төсөл нарийвчлан гаргаж ирэх ёстой гэж ойлгоод байгаа. Зөв байх. Тийм ээ.

Тэгэхээр үндсэндээ бидний зөвшөөрөхгүй байгаа ТЭЗҮ-г хийсэн компаниараа дахиад зураг төслөө хийлгэнэ гэдэг нь хэр зөв байдаг юм бэ гэдэг эхний асуулт байна.

Хоёрдугаар асуулт. Мэдээж 260 мегаваттын дутагдалд ороод байна гэж байна.

Тэгвэл энэ төсөл маань өөрөө хэрэгжээд энэ хэлэлцээрийн үр дүнд хэзээ ашиглалтад орох вэ?

Эхний танилцуулга дээрх хугацаагаар 5 жил гэсэн байна.

Тэгэхээр 5 жилийн дараагаас 260 мегаваттын нэмэлт боломж нь гарч ирэх юм уу?

Нөгөө талаас Бөөрөлжүүдийн цахилгаан станц хэзээ ашиглалтад орох гэж байгаа билээ?

Тэдний хот руу нийлүүлэх эрчим хүчний хэмжээ нь хэд билээ?

Энэ хоёр чинь хоёулаа давхар заавал байх ёстой байгаа юу, аль нэг нь нөхөөд явах боломжтой байгаа юу гэдэг хоёр дахь асуулт байна.

Гуравдугаар асуулт. Зарчмын зөрүүтэй саналууд солилцсон гэж байна шүү дээ.

Тэгэхээр тэр зарчмын зөрүүтэй саналууд дунд яг Монгол Улсаас гаргасан зарчмын зөрүүтэй санал юу байсан бэ гэдгийг бас тодруулж асуумаар байна.

Үүн дотроо энэ хэлэлцээрийн төслийг харахаар үнийн дүн байхгүй байгаа юм.

Тэгэхээр үнийн дүн өөрөө Монгол Улс төсвөөсөө гаргана гэхсэн байж байгаа. Тэгэнгүүт тэр үнийн дүнг тодорхойлох нь өөрөөр хэлбэл тэр гүйцэтгэгч байгууллагын л санал болгох гээд байна шүү дээ.

Тэгэхээр тэр үнийн дүнгийн талаар энэ хэлэлцээртээ тусгахгүй байсан уу гэдэг ийм гурван асуулт байна.

Р.Сэддорж: Хариулт 3 номер.

Б.Чойжилсүрэн: Г.Уянгахишиг гишүүний асуултад хариулья.

Өөрийн чинь хэлж байгаа ийм шүүмжлэл гарна.

Барилга угсралтын ажлыг хийх компани нь “Интер РАО Экспорт”, зураг төсвөө бас “Интер РАО Экспорт” хийнэ гэсэн.

Энэ нөхцөлийг хүлээн зөвшөөрвөл Оросууд хамтарч ажиллая, эс бөгөөс больё гэж байгаа юм. Ерөөсөө шулуухан.

Хэзээ ашиглалтад орох вэ гэхээр одоо ТЭЦ-III-ын хашаанд 50 мегаваттын цахилгаан, 100 мегаваттын дулааны блок зуухтай 1 станц шинээр барина гэсэн үг.

Үүнийгээ барьж ашиглалтад оруулчхангуутаа одоо байгаа, ашиглалтын хугацаа дуусчихсан байгаа 4-ийг үржих 12 турбинтэй зуухуудыг одоо байгаагийн дунд даралтыг бүгдийг нь нураагаад зайлуулна.

Энэ суурин дээр нь 2-ыг үржих 125 мегаваттын блоктой цахилгаанаар, дулаанаар 300 мегаваттын блоктой ийм 2 станц баригдана гэсэн үг.

2029 он хавьцаа ашиглалтад орох болов уу гэж найдаж байгаа.

Эхлээд нэгийг нь барьж дуусгачхаад, 2 станц барих гээд байна шүү дээ. Бодит байдал дээр.

Тэгээд нөгөөдхөө буулгачхаад дахиад шинээр блок барих ийм л байгаа юм.

Энэ Бөөрөлжүүт бол зүгээр энэ хувийн төсөл хэрэгжүүлж байгаа станц шүү дээ.

600 мегаваттын хүчин чадалтай ийм төсөл хэрэгжүүлж байгаа.

Эхний 150 мегаваттын 1 блок энэ 11 дүгээр сард ашиглалтад орох болов уу

гэж найдаж байгаа. 2 дахь блок нь ирэх оны 11 дүгээр сард ашиглалтад оруулъя гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байгаа.

3, 4 дэх блокийг нь саяхан бид зөвшөөрлийг нь гаргаж өгөөд, одоо хэлэлцээрийг хийгээд явж байна.

Яг энэ дээр магадгүй бас 3, 4 жил асуудал ярих байх. Яг хөрөнгө оруулагч өөрөө шийдэх болов уу гэсэн ийм юу байна.

Монгол Улсаас гаргасан санал гэхээр үнэ чинь нь их байна. Буулга.

Хамгийн дээд тал нь 814 сая доллар байвал ярилцаж болно. Үүнээс чинь илүү үнэтэй юм бол би чадахгүй ээ гэсэн.

Рублиэр өг өө, зээлийнхээ хугацааг сунга аа, хүүг нь буулга аа гэсэн ийм саналууд байгаа.

Оросууд үнээ буулгая гэхээр зураггүй байна. Зургаа хийчих тэгвэл. Тэгвэл үнээ тохирьё гээд.

Тэгэхээр одоо ингээд хоёр тал л аль алиндаа ингээд яваад байна шүү дээ.

Айхтар тийм хэрэгжүүлчихье гээд яарч байгаа юм бас оросуудад анзаарагдахгүй байгаа байхгүй юу.

Гэсэн мөртөө бид нар үүнийг чинь хэрэгжүүлнэ гээд байдаг. Манай хөршийн хувьд та бүхэн мэдэж байгаа. Цахилгаан эрчим хүч, нефть бүтээгдэхүүн гээд янз бүрийн юмнууд байдаг биз дээ. Бид нар чинь.

Р.Сэддорж: Тодруулга авах юм уу? 3 номер.

Б.Чойжилсүрэн: Г.Уянгахишиг гишүүний асуултад хариулъя.

Дутуу хариулсан байна. Уучлаарай.

19.7 орчим сая доллар болох болов уу гэсэн ийм баримжаатай байгаа.

Анх “Интер РАО” эрихдээ 37 сая байх аа. Санал ирүүлсэн. Ийм юм байхгүй ээ. Ийм мөнгөөр бид ийм үнээр хийлгэхгүй ээ. Үүнийгээ буулга гээд шахсаар байгаад хамгийн сүүлийн санал нь 19.8 сая еврогоор хийе гэдэг.

Үүнийг ТЭЦ-III өөрөө санхүүжүүлэхээр. Мөнгөн дүнг нь. ТЭЦ-III-ын өмч болно гэсэн үг. ТЭЗҮ нь зурагтайгаа.

Р.Сэддорж: Тодруулга уу? Г.Уянгахишиг гишүүн тодруулга.

Г.Уянгахишиг: Хоёр дахь асуултын хариулт дээр одоо ингээд Бөөрөлжүүтийн эхний төслүүд 11 сард ингээд ингээд эхний 2 үе шат нь болчих юм байна шүү дээ.

Тэгэхээр нөгөө дутагдаад байгаа цахилгааны маань хэрэгцээг хангачхаж чадах болов уу гэдэг нэг тодруулга асуулт нь.

Гурав дээр болохоороо үнийн санал 19.7 сая евро гэж байна шүү дээ. Тийм ээ. Тэгэнгүүт энэ нь өөрөө хэлэлцээр дээрээ тусгагдаагүй байна. Нөгөө талаас 30 хэдэн сая евро гэдэг санал тавьсан юм байна.

Тэгэхээр нөгөө хуульч хүний хувьд хараад байгаа нь энэ талд нэг өөр дүн. Энэ талд нэг өөр дүн байгаад байдаг. Яг нэгдсэн нэг дүн буулгасан тэр цаас нь

хаана байна вэ? Үг үсэг нь хаана байна вэ гэдэг.

Р.Сэддорж: 3 номерын микрофон. Б.Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Яагаад энэ үнийг тавьж орж ирээгүй юм бэ гэхээр ингэнэ. Г.Уянгахишиг гишүүн ээ.

Одоо ингээд яг хөрсний геологийн судалгааг хийнэ. Ямар хөрш гарч ирээд ямар хэмжээний төвөгшилтэй ямар хүчитгэл хийх гэдэг нь геологийн судалгааны дараа тодорхой болох юм.

Магадгүй гайгүй бидний аз түших юм бол тодорхой хэмжээнд хэмнэгдэхийг үгүйсгэхгүй.

Хөрс жоохон хүндрээд эхлэх юм бол нэмэлт арга хэмжээнүүд суух учраас оруулаагүй. Ер нь баримжаа бол энэ хавьцаа л байна.

Р.Сэддорж: Дараагийн гишүүн Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууж үг хэлнэ.

М.Энхцэцэг: Энэ төсөл ерөнхийдөө нэлээн дээр үеэс яригдаж байсан ийм төсөл. Яагүй олон жил явагдахгүй байгаа.

Би нэг асуулт асууя.

Хүчин чадлыг өргөтгөж байгаа учраас ТЭЦ-III-ын гаднах хуваарилах байгууламж бас өргөтгөх ёстой.

Тэгэхээр энэ зураг төслийн ажил, тэр гадна талын хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил орж байгаа юу гэсэн ийм асуулт байна.

Хоёрдугаарт нь, сая зураг төслийн үнийг 20 орчим гэж байна.

Тэгэхээр энэ дээр олон улсын жишгийг. Монголд одоогоор яг ийм дулааны цахилгаан станцын зургийг хийсэн тийм жишээ авчихаар юу байхгүй байгаа.

Тэгэхээр зүгээр олон улсын хувьд. Энэ чинь нэгэнт л олон улсын гэрээ учраас яг иймэрхүү хэмжээний өргөтгөл, иймэрхүү хэмжээний станцуудын зураг хэр хавьцаа хийгдэж байгаа гэсэн тийм жишиг тооцоо судалгаа хийсэн үү гэсэн ийм хоёр асуулт байна.

Р.Сэддорж: Б.Чойжилсүрэн сайд 3 номер.

Б.Чойжилсүрэн: М.Энхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Хуваарилах байгууламж зураг төсөвтөө орчихсон.

Хоёр бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ шүү дээ. Цахилгаан эрчим хүч, дулааны эрчим хүч. Хоёуланг нь борлуулдаггүй. Төсөл ашиглалтад орсон өдрөөс эхлээд бүрэн борлуулалт хийдэг байх ийм нөхцөлийг л бүрдүүлнэ.

Ингэхгүй бол энэ төсөл өөрөө өртгөө нөхөхгүй юм билээ.

Р.Сэддорж: М.Энхцэцэг гишүүн тодруулга байгаа юу, байхгүй юу?

М.Энхцэцэг гишүүн тодруулъя.

М.Энхцэцэг: Зураг төслийн хувьд хэр юу байгаа вэ гээд. Тийм ээ. Олон улсын судалгаа байна уу?

Р.Сэддорж: Хариулт. 3 номер. Б.Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: М.Энхцэцэг гишүүн ээ, бид нарт Монгол Улсад өөрөө ийм хэмжээний станц барьсан туршлага сүүлийн 30 жилдээ алга байна. Тэр ойлгомжтой.

Би танд зүгээр хэдэн жишээ ярья гэж бодож байна.

Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 мегаваттаар өргөтгөж байгаа.

Энэ төсөл дотор зураг төслийнх нь үнэ нь 2.6 хувь буюу 2.1 сая доллар байна.

Тавантолгойн эхний ээлжийн 300 мегаваттын дулааны цахилгаан станц барих төсөл тендерт 2 компани санал ирүүлсэн. Нэг нь 10.5 сая ам доллар, нөгөөдхийнх нь зураг төслийн үнэ 12 сая ам.доллар гэсэн ийм үнийн санал ирүүлсэн.

Бөөрөлжүүтийн 300 мегаваттын цахилгаан станцын төслийг бид энэ төслийнхнөөс асуусан. Хувийн компани санхүүжүүлж байгаа ийм төсөл. 555.7 сая доллароор 300 мегаваттыг барих. Зураг төсвийнх нь үнэ 13.8 сая доллар гэсэн.

Р.Сэддорж: Б.Чойжилсүрэн сайд үргэлжлүүлж хариулах уу? Дуусгах уу? 3 номер.

Б.Чойжилсүрэн: Хоёрдугаарт, энэ ийм шүү дээ.

Аягүй төвөгшилтэй хийчихсэн.

2 станц шинээр барина гэсэн үг. Бараг. 50 мегаваттай 1 блок, 100-гийн зуухтай.

Дахиад 250-ын 2 турбин, дахиад 300-гийн зуухтай.

Тэгээд одоо байгаа. Та өөрөө мэдэж байгаа. Манай салбарын хүн бол. ТЭЦ-IV дээр байгаа ашиглалтын хугацаа дуусчихсан. Хэдий нь мэдэгдэхгүй. Зогсоход бэлэн болчихсон байгаа.

Энэ нам даралтын 12-ыг үржих 4 блокыг бас зайлуулна.

Магадгүй тэр 20-иод сая доллар болох юм шиг байна лээ. Тэр зайлуулах зардал нь. Зөвхөн.

Иймэрхүү төвөгшил өндөртэй төсөл байгаа.

Гол нь бид Улаанбаатар хотын дулаан хангамжийг ТЭЦ-III маань хамгийн тохиромжтой байрлал дээр байгаа эх үүсвэр байхгүй юу.

ТЭЦ-IV бол баруун тийшээ дахиад 3 километр холдчихно. Үр ашиг муутай.

Яг энэ хотын төв рүү, яг техникийн нөхцөл хүсэж байгаа энэ.../минут дуусав/

Р.Сэддорж: 50 мегаваттынх 2.5 сая доллар болсон юм уу? Зураг төсөв нь.

Б.Чойжилсүрэн: 2.1.

Р.Сэддорж: Тэгээд хэд дахин том юм? Одоогийнх. 50-иас.

Б.Чойжилсүрэн: 6 дахин том.

Р.Сэддорж: 6-г 2.5-аар үзүүлэхэд хэд вэ?

Зураг төсөв тиймэрхүү юм байна. Тийм ээ.

Дараагийн гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Энхтүвшин: 2 асуулт байна.

Нэгдүгээрт нь, гэрээний хэлэлцээрийн агуулгыг хараад үзэхээр энэ гарчигтайгаа нийцэхгүй байгаа гэдэг нь харагдаад байна л даа.

Тэгэхээр яах вэ, зүгээр хүмүүсийн хувьд хараад үзвэл зураг төслийн боловсруулах гэрээ гэж байгаа боловч яг доторх, одоо жишээлбэл 4 дүгээр заалт бол гүйцэтгэлийн шимтгэлтэй холбоотой гэрээ байна л даа.

Тэгэхээр нэрээ солих ёстой юм уу, эсвэл доторх агуулгаа солих ёстой юм уу? Энэ талаар бас нэг тодруулж өгөөч?

Энэ доторх юмнууд нь цахилгаан станцын өргөтгөл шинэтгэлийн зураг төсөл боловсруулах хэлэлцээр гэж байгаа байхгүй юу.

Тэгэнгүүт дотор нь болохоор үргэлжлүүлээд. Ер нь энэ гэрээгээр үүнийг үргэлжлүүлж барина л гэсэн гэрээ байна л даа.

Тэгэхээр яах вэ, энэ дээр нэг тодруулга хүсэж байна.

Хоёрдугаарт нь, хөрөнгө оруулалтын өртөг энэ төслийн хувьд нэлээн өндөр болохоор тийм тооцоо гарч байна.

Тэгэхээр 1 киловатт цагийн өртөг одоо жишээлбэл сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтын зардлууд өндөр гээд. Одоо жишээлбэл ихэнх нь сүүлийн үед бид шинэ эх үүсвэр баригдаагүй учраас одоо нөгөө нэг санккос гэдэг шиг ингээд өртөггүй болчихсон үл хөдлөх хөрөнгийн элэгдлийн зардал бараг байхгүй болчихсон шахуу ийм юман дээр өртөг тооцоод сэргээгдэхтэй харьцуулаад асуудал яриад байдаг.

Тэгэхээр яг одоо энэ шинээр том ийм нүүрсээр ажилладаг өртөг өндөртэй энэ эх үүсвэрүүд бариад ирэхээр энэ нь өртөг нь сэргээгдэхтэй харьцуулахаар ямаршуу байдалтай гарчхав аа. Тэр талаар мэдээлэл өгөөч ээ.

Р.Сэддорж: Хариулт. 3 номерын микрофон.

Б.Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Д.Энхтүвшин гишүүн ээ, энэ зураг төслийн гэрээ байгуулна шүү дээ.

Тэгэхээр гэрээг татвараас чөлөөлж байгаа юм. НӨАТ-аас, аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас, гаалийн татвараас чөлөөлж байгаа юм. Энэ үйл ажиллагаанд.

Зураг төсөл боловсруулах үйл ажиллагаанд нь шүү. Зөвхөн.

Хоёрдугаарт, энэ 19 сая болно. Одоо нэг шинжилгээний дүн гарна.

Энэ нь Монголын талын санхүүжилтэд орж тооцуулна.

Дараагийн байгуулагдах гэрээ байна шүү дээ. Ирээдүйд байгуулагдах гэрээтэйгээ уялдана.

Хэрвээ Оросын Холбооны Улс юу санхүүжүүлэх юм бол оросууд бол 15, 85-аар. 85-ыг нь оросууд, 15-ыг нь монголчууд санхүүжүүл гээд байгаа.

Бид 5 хувийг нь Монголд санхүүжүүлье. 95 хувийг нь танайх санхүүжүүлчих гээд.

Энэ Хятадын ЭКСИМ-ийг би бас Сангийн сайд байхдаа ингэж 85, 15-ыг 5, 95 болгож байсан юм. Үүгээр ингээд явж байгаа юм.

Тийм учраас ингэж ойлгогдож байгаа болов уу гэж.

Сэргээгдэхийн тухайд хоёр хүндрэл байна.

Сүүлийн үед сэргээгдэхийн үнэ өртөг бууж байгаа.

Узбекстанд жишээлбэл нар салхины хайбрид станц 2.7 центгээр 1 киловаттыг нийлүүлнэ гэсэн ийм үнийн санал ирсэн.

Манайд одоохондоо ийм үнээр нийлүүлээгүй. Дандаа 15 орчим центийн үнэтэй ийм гэрээ байгуулчихсан. 6 нарны станц, 3 салхины станц үйл ажиллагаа явуулж байгаа.

Дээр нь урьд нь тусгай зөвшөөрөл авчихсан байгаа 8 нарны станц, 3 салхины станц байна.

Нийт хүч чадал нь 345 мегаватт байх. Би зөвшөөрөл бичээд өгчихсөн. Эд нар дээр бид ингээд наана цаана болоод ингээд гацаад зогсчихсон байгаа.

Үнээс гадна хамгийн том асуудал. Одоо бид тохируулах ийм ресурс нөөц шавхагдсан.

Оросын Холбооны Улсаас ерөөсөө 345 мегаваттад нь тулгаад авчгаж байгаа юм. 2 хэлхээтэй 220 киловаттын шугамаар дамжуулж болох хамгийн дээд талаар авчихсан.

Нар ороод, эсвэл салхи зогсчихсон үед яг ийм чадлыг бид хаа нэг газар нөөцлөх ёстой. Нөөцөлж чадахгүй байгаа учраас энэ сэргээгдэхийн төслүүд явагдахгүй байгаа. Ийм хүнд байгаа. Техникийн хувьд.

Бид нэг “battery storage”-той. 400 мегаваттын battery storage бариад 4 цагаар нийлүүлэх.

Үүнтэйгээ зөв багцлаад 500 мегаватт хүртэл нар, салхины хосолмол станц нэг тендер зарлаж үздэг юм уу гэсэн ийм төлөвлөгөөтэй, мөрийн хөтөлбөрт суусан. Та бүхэн мэдэж байгаа.

Үнийн хувьд тэр storage-ийнхоо хөрөнгө оруулалтыг бас нөхөх хэрэгтэй болно оо доо. Бид сэргээгдэхээс биш хямдхан авч байж явах ёстой байх.

Одоо бид жишээлбэл storage аягүй төвөгтэй. Bankable болж өгөхгүй байна.

Шөнийн үед 2 центээр өгөөд, оргил ачааллын үед 15 центээр буцаагаад сүлжээндээ авахад 13, 14 жилийн дотор дөнгөж хөрөнгө оруулалтаа нөхдөг. Бүр хөнгөлөлттэй эх үүсвэрээр тооцоод байхад.

Зах зээлийн хуулиар тооцохоор болохгүй байна. Магадгүй энэ storage шинжлэх ухаан хөгжөөд хэдэн жилийн

дараа бас өртөг нь буух байлгүй гэсэн ийм л байр суурьтай байгаа.

Р.Сэддорж: Д.Энхтүвшин гишүүн тодруулга.

Д.Энхтүвшин: Би асуултаа буруу. Ойлгуулж чадаагүй юм шиг байна.

Нэгдүгээрт, энэ гэрээнийх нь нэр нь өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл боловсруулах гээд. Гарчигтаа агуулгаа тааруулах уу, агуулгадаа гарчгаа тааруулах уу? Энэ талаар нэг асуулт байгаа.

Нөгөөдөх нь, яг энэ хөрөнгө оруулалтын өртөг зардал нэлээн өндөр болж байгаа учраас яг энэ станцаар жишээлбэл эрчим хүч үйлдвэрлэхэд ямаршуу өртөгтэй багцаа болох бол?

Одоо ерөнхийдөө урьдчилсан байдлаар жишээлбэл тооцоонууд хийчихсэн юм шиг байна шүү дээ. Тийм ээ. Нэг аравны хэд гээд зөрүүтэй дүнгүүд байна. Тэр талаар тийм хоёр юм асуусан.

Р.Сэддорж: Хариулт 3 номер. Б.Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Д.Энхтүвшин гишүүн ээ, одоо би танд ойлгуулж чадахгүй байх шиг байна. Уучлаарай.

Энэ бол зураг төсөл боловсруулна гээд цагаан дээр хараар бичээд таны ширээн дээр л байгаа.

Ондоо ямар ч барилга угсралтын ажил хийхгүй. Барилга угсралтын ажлын гэрээ байгуулах үндсэн бичиг баримт болох барьж явах суурь нөхцөл маань ийм л юм байгаа юм.

Ер нь тэр тэрбум 326 сая еврогоор нь Оросуудын тавьсан жилийн 2 хувийн хүүтэй тэр экспортын зээлээр нь ингээд явахаар 9 центээр сүлжээнд нийлүүлж байж тэр зээлийн хугацаанд 10, 20 жилийн дотор станц өртгөө нөхөж магадгүй ийм тооцооллууд гараад байгаа.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзвэл 1 минут. Д.Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Б.Чойжилсүрэн сайд аа, 4 дүгээр зүйлийг Та харвал энэ зураг төслийн гэрээ биш байгаа байхгүй юу.

Одоо энэ дээр өргөтгөл шинэчлэлийг цаашид ийм, санхүүжилтэд нь ийм юмыг тооцно, тэгээд энэ цаашаа барих үргэлжлүүлэх асуудлууд Монгол.

Одоо энэ 4-ийг та уншаад үзвэл энэ яг зураг төслийн гэрээ биш болчихоод.

Би зүгээр тэр утгаар нь асуусан юм.

Тэгэхээр дараа нь жишээлбэл энэ агуулга нь өөр болохоор юу тийм. Тэгээд сая юу би 9 цент гэдгийг яалаа.

Тэгэхээр яах вэ, ер нь сэргээгдэхтэй бас ер нь нэлээн ойрхон очиж байгаа гэсэн ийм үзүүлэлт болж байгаа юм байна шүү дээ. Тийм ээ. Өртөг зардлын хувьд одоо хийж байгаа гэрээнүүдтэй энэ нүүрсний станц маань одоо ингээд бариад борлуулах өртөг нь 9 центээр борлуулалт хийгээд ашигтай ашиггүй байх уу гэдэг юм байна гэж ойлголоо. Зөв үү?

Р.Сэддорж: Хариулт. 3 номер.

Б.Чойжилсүрэн: Д.Энхтүвшин гишүүн ээ, би энэ орос хувилбар дээр нь.

Монголын тал санхүүжүүлнэ. Санхүүжүүлсэн дүнгээ Монголын талын хөрөнгө оруулалтад тооцно гэсэн ийм заалт байгаа. Тийм.

4-ийг цаашаа үргэлжлүүлээд явахаар энэ хэлэлцээрийн суурь нөхцөл нь энэ.

Энэ гэрээний зураг төсөв боловсруулж байж үнээ тодорхой болгож байж цаашдын хэлэлцээрүүд явна.

Эс бөгөөс үнэ тодорхой болохгүй бол энэ хэлэлцээр цаашаа явахгүй ингээд зогсоно гэдэг ийм л утгатай.

Р.Сэддорж: Саруулсайханы Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Оройн мэнд хүргэе. Ерөнхийдөө энэ гэрээтэй холбоотойгоор бас олон материалуудтай танилцаж үзлээ.

Тэгээд ерөнхийдөө бас олон ч удаа яригдаж байсан учраас удаа дараа манайд Монголын талаас Өрийн удирдлагын тухай хуульд нийцэхгүй гэдгийг олон удаа хэлж байсан.

Тэгэхээр энэ хөнгөлөлттэй зээлийн нөхцөл гэж нэрлээд байгаа ч гэсэн Олон Улсын Валютын Сангийн Grand Element гээд хөнгөлөлттэй зээлийг тооцдог түвшнээр нь аваад үзэхээр ядаж 15 хувьтай байх юм бол энэ хөнгөлөлттэй зээлийн түвшинд хүрнэ гэж үздэг.

Гэтэл энэ зээлийн гэрээний нөхцөл нь 2.9 буюу маш бага байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ ерөөсөө хөнгөлөлттэй зээл гэж тооцогдохгүй байгаад байгаа юм. Бодит амьдрал дээр хараад үзэхээр.

Тэгэхээр бид энэ гэрээг хийх гэхээсээ илүүтэй энэ дээр гэрээний нөхцөл дээрээ ахиад сайн ярилцах ёстой юм биш үү.

Бид энэ дээр хараад үзэхгүй бол хөнгөлөлттэй зээл гэж нэрлэж байгаа ч гэсэн цаана нь Монгол Улсын татвар төлөгч нар бид энэ мөнгийг буцаагаад нөхөх шаардлага гарна. Хүн болгоны карманаас л гарч ирнэ гэсэн үг.

Тэгэхээр энэ дээрээ бид аягүй сайн тооцох хэрэгтэй байгаад байна.

Тэгээд нөгөө талдаа болохоор Г.Уянгахишиг гишүүний асуусан асуулттай бас миний асуулт давхацчихлаа л даа. 1.3 тэрбум евро гэж ярьж байсан.

Гэтэл бид өөрсдөө хийгээд үзэхээр энэ маань хамаагүй хямдхан гарч болоод байсан.

Тэгтэл бид үүнийгээ хөндлөнгийн зураг төслийн компани гаргаж ирж байж энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай учраас энэ дээр хөндлөнгийн компаниар хийлгэх боломж байхгүй юу гэдгийг бас ахиад.

Р.Сэддорж: Хариулт 3 номер.

Б.Чойжилсүрэн: С.Цэнгүүн гишүүний асуултад хариулья.

Энэ өрийн удирдлагын тухай холбогдох заалтуудыг би Сангийн сайд байхдаа санаачилж оруулж байсан юм.

Оросуудыг энэ үнийг нь буулгахын тулд энэ Өрийн удирдлагын тухай хуультай нийцэхгүй байна гээд бид

байнга бичиж байгаа. Хүүгээ буулгаж өг гээд.

Тэгэхээр өөрийн чинь яриад байгаа тэр хэлэлцээр дөнгөж эхний шатандаа очоод нөгөө гэрээнийхээ үнэ зураггүй учраас үнэ дээрээ тохирч чадаагүй байгаа учраас цаашид дараагийн хэлэлцээрүүд зогсчихоод байгаа байхгүй юу.

Түүнээс биш наадах чинь бол зүгээр бид нарт Оросуудын авчирч тавьсан саналыг бид та нарт юу ч нуухгүйгээр бүгдийг нь байгааг нь бичээд оруулчихсан л юм.

Түүнээс биш өөртэй чинь санал нэг байна. Ойлгомжтой. Энэ Өрийн удирдлагын тухай хууль болон Монгол Улсын бүх хуулийг дагаж мөрдүүлэх тал дээр ажиллана.

Ондоо юу билээ. Санхүүжилтийн хэлэлцээр ч тусдаа, барилга угсралтын гэрээ ч тусдаа.

Дахиад аягүй хоёр. Засгийн газар хоорондын хэлэлцээрүүд 2 байгуулагдахыг үгүйсгэхгүй. Гурав болчхож магадгүй.

Энэ дээр бид Олон Улсын Валютын Сангийн нөлөөг ийм ийм хүндрэлтэй байна гэдгээ өөрийн чинь байр суурийг илэрхийлээд Хятад, Оросуудыг буулга гээд гуйгаад байгаа юм.

Р.Сэддорж: Нэмж хариулах хүмүүс байна уу? 5 номер. 3 номер.

Б.Чойжилсүрэн: Нэг асуулт. Би дутуу хариулсан байна. С.Цэнгүүн гишүүн ээ.

Яагаад хөндлөнгийн компаниар хийлгээгүй юм бэ гэдэг ийм асуулт тавьж байна шүү дээ.

Ер нь ерөнхийдөө бид энэ ТЭЦ-II дээрээ жишээлбэл энэ хөндлөнгийн компаниар яг зах зээлийн үнээр хийхээр яг ижилхэн төсөл явуулж байгаа. Одоо.

Энэ Оросын Холбооны Улстай энэ ТЭЦ-III-ын асуудлыг яг хоёр орны харилцааны хувьд манайх бас янз бүрийн байдлаар хараат гэдгээ бас бид ойлгох хэрэгтэй.

Тэгээд ямар ч байсан ингээд зах зээлийн үнэ ханшид хүртэл нь бид хэлэлцээр явуулна. Эс бөгөөс энэ хэлэлцээр байгуулагдахгүй.

Оросууд бид өөрсдөө тендерт орохгүй Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулаад манай компанийг тендерт ялагчаар. Олон улсын гэрээ байгуулна гэсэн үг шүү дээ. Монголын тендерийн хууль.

Ийм нөхцөлд цаашаа явъя. Эсвэл бид больё гэж байгаа байхгүй юу.

Түүнээс биш манайхыг нэг их гуйгаад байгаа юм огт байхгүй.

Р.Сэддорж: Тодруулга байгаа юу? С.Цэнгүүн гишүүн. Байхгүй байна.

Энэ хэлний талаар ярьсан шүү дээ? Тийм ээ. Одоо Монгол Улсын Үндсэн хуульд ч байгаа, хэлний тухай хуулиудад ч байгаа.

Тэгээд тэртээ тэргүй л цахилгааны, эрчим хүчний үг хэллэгүүд монгол хэл дотор орсоор явж байдаг шүү дээ. Дандаа.

Тийм учраас орос, монгол, англи хэл дээр хийвэл яасан юм бэ. Энд нэг их сүртэй зардал гарахгүй байх гэсэн ийм саналыг албан ёсоор оруулж байна.

Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн үг хэлж, асуулт асууна.

Ч.Лодойсамбуу: Саналууд, асуултууд үндсэндээ бид нэг тодорхой л юм асуугаад байна л даа. Нэг юмаа л бүгдээрээ асууж байна.

Энэ өндөр үнэтэй төслийг хэтэрхий өндөр үнэтэй байна гээд л манай Эдийн засаг, хөгжлийн яамнаас хүртэл саналаа хэлсэн л юм билээ л дээ.

Тэгээд манай Өрийн удирдлагын тухай хуулийн шаардлагыг ч гэсэн хангахгүй байна гээд л саналуудаа хэлсэн юм билээ.

Тэгээд хэлэлцээрийн төслийг харахад хэлэлцэнэ гэхээсээ илүүтэй тулгаад байгаа юм шиг заалтууд зөндөө байна. Манай өмнөх гишүүд бас хэлсэн.

Тэгээд би цаг хэмнээд асуулттай тэргүй давхцаж байгаа. Дараа дараагийн Байнгын хороод таныг хүлээж байх шиг байна.

Ингээд саналаа, үгээ дуусгая.

Р.Сэддорж: Ч.Лодойсамбуу гишүүн санал хэллээ. Тийм ээ.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Саяын гишүүдийн хэлсэн санал, хүсэлтүүдийг протоколд нарийн тэмдэглээрэй.

Одоо дараагийн Байнгын хорооны хурал шууд орох учраас саяын саналууд дэлгэрэнгүй тусгах боломжгүй юм байна.

Ингээд яг хэлсэн протокол, Улсын Их Хурлаас протокол, албан ёсоор хүн ирчихсэн протокол хөтөлж байна.

Саяын гишүүдийн хэлсэн санал хүсэлт, зөвлөмжүүдийг бүгдийг нь тусгаад явах нь.

Сая хэлний талаар би өөрөө Улсын Их Хурлын гишүүний хувьд хэллээ.

Энэ монгол хэл дээр байх ёстой.

Хоёрдугаарт нь, орос хэл дээр давхар явах ёстой. Англи хэл дээр явж.

Дэлхийн хэмжээнд эрчим хүч ярьж байгаа бол хэдүүлээ англи хэл дээр байх ёстой гэж үзэж байна.

Ингээд Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

68.8 хувиар дэмжигдсэн байна.

Протокол тэмдэглүүлэх хүмүүс, төхөөрөмж гацсан хүмүүс байна уу?

Орсон уу? Миний юу бол одоо яг ажилласангүй.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай танилцуулна.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон нийт гишүүдээ баярлалаа.

Хуралдаан 50 минут үргэлжилж, 17 цаг 00 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД